


БАТЛАВ.


ЦЭНГЭГ УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ТӨВИЙН ЗОХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.ДАВААЖАВ

БАТЛАВ.

“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ
СУРГАЛТЫН ТӨВ” НҮТББ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.ШИНЭЦЭЦЭГ

“МИНИЙ МЭДЭХ АМЬД БАЙГАЛЬ”

СЭДЭВТ ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

№ 2021/03

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Бидний орон гэр болох Эх Дэлхий маань амьдралын онцгой нийгэмлэг бүхий амьд ертөнц юм.¹

Хүүхэд багачуудыг бага наснаас нь хүн ба хүрээлэн буй орчны холбоо хамаарал, хүрээлэн буй орчныг хайрлан хамгаалахад хүмүүсийн оролцоо чухал болохыг ойлгуулах, үүнтэй холбоотой асуудлаар байр суурь, үзэл бодлоо илэрхийлдэг болгон хөгжүүлэх тэдний идэвхтэй оролцоог хангах нь чухал юм. Иймд хүүхэд багачуудын дунд “Миний мэдэх амьд байгаль” сэдэвт гэрэл зургийн уралдааныг зарлаж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Бидний эргэн тойронд дахь амьд байгаль, амьтан, ургамлыг ажиглах, байгаль, нийгэмтэй харилцах явцад өөрийгөө нээн таньж, ойр орчмынхоо амьд биесийг хайрлан хамгаалах сэдлийг төрүүлсэн зургийг гэрэл зургийн агшинд буулган олон нийтэд сурталчлан, таниулахад чиглэгдэнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ, УРАЛДААНЫ ТӨРӨЛ

Үндэсний хэмжээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын 11-14 насны сурагчдын дунд “Баримтаг” болон “Зохиомжит” гэсэн 2 төрлөөр явагдана.

¹ <https://earthcharter.org/>

ДӨРӨВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага	1. Гэрэл зургийн нягтрал 300 dpi –с доошгүй, JPG эсвэл PNG форматтай байх;
	2. Гэрэл зурагтаа 140 тэмдэгтэд багтаан нэр өгөх;
	3. Зургийн тайлбар 120 үгнээс хэтрэхгүй байх ёстой бөгөөд тайлбарт шийдлийг тусгасан байна. Ашигласан аливаа баримт, статистик тоо, ишлэлийн эх сурвалжийг тодорхой дурьдах;
	4. Гэрэл зураг нь эх хувиар байх ёстой ба засвартай зургийг хүлээн авахгүй;
	5. Уралдаанд оролцогч нь овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, аймаг /хот/, сум, холбоо барих утасны дугаар, имэйл хаяг, бх᠑ хэмжээтэй өнгөт цээж зургийн хамт зарласан хугацаанд гэрэл зурагтайгаа хамт ирүүлэх
	6. Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд зохион байгуулагчдын гэрэл зургийн сан хөмрөгт зохиогчийн эрхтэйгээ үлдэнэ
	7. Оролцогчийн эцэг, эх, асран хамгаалагч нь зохиогчийн эрхийн асуудлыг хариуцах болно. Зөвхөн өөрийн авсан гэрэл зураг байх ёстой бөгөөд зохиогчийн эрхийн асуудал үүссэн тохиолдолд зохион байгуулагч тал хариуцахгүй
	8. Уралдаанд ирүүлсэн гэрэл зураг зохион байгуулагчдын сан хөмрөгт зохиогчийн эрхтэйгээр үлдэнэ. Мөн оролцогчдын бүтээлийг сонин хэвлэл, цахим сүлжээнд нийтлэх, сурталчилгааны ажилд ашиглах эрхийг уралдаан зохион байгуулагчид байгууллагуудад зөвшөөрнө.
	9. Уралдаанд нэг хүн нэг бүтээлээр оролцох боломжтой
	10. Таны зураг RAW файл бол JPG форматруу хөрвүүлсэн байх шаардлагатай. Эх зургийн талаарх танилцуулга буюу хэзээ, ямар камераар авсан тухай мэдээлэл компьютер дээр шалгахад байх ёстойг анхаарна уу.
Агуулгын шаардлага	1. Бүтээлийн зохиомж, агуулга, ур чадвар, бүтээлийн нэр, тайлбар, тухайн бүтээл чанарын шаардлага хангасан эсэхийг харгалзана
	2. Өөрийн амьдарч буй орчин дахь амьд байгалийг илэрхийлсэн байдал
	3. Асуудалд тэнцвэртэй бодитой хандсан байх;
	4. Дэвшүүлсэн асуудлыг тал бүрээс нь авч үзсэн байх
	5. Гэрэл зураг нь тэнцвэртэй, олны анхаарлыг татаж, нийгмийн сэтгэлзүйд хүрэхүйц, асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж санал болгосон байвал зохино.

Түгээсэн байдал	1. Гэрэл зургаа өөрийн хувийн цахим сүлжээгээр олон нийтэд түгээсэн байх бөгөөд олон нийтэд түгээснийг нотлох баримтыг гэрэл зургийн хамт илгээнэ.
-----------------	--

ТАВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ, ШАЛГАРУУЛАХ

Уралдааны бүтээлийг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний 17:00 цаг хүртэл yremongolia@gmail.com хаягаар хүлээн авна.

Уралдаанд ирүүлсэн бүтээлийн агуулгын болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу уралдаан зохион байгуулах ажлын хэсэг дүгнэж, шалгаруулах бөгөөд уралдаан 2 үе шаттай зохион байгуулагдана. Үүнд:

I шат - Оролцогчдын бүтээлийг 2021 оны 04 дүгээр сарын 10-наас 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл цахим сүлжээнд байршуулж, цахим хандалт болон шүүгчдийн саналыг үндэслэн эхний 10 бүтээлийг шалгаруулна.

II шат- Мэргэжлийн гэрэл зурагчин болон зохион байгуулагчдын төлөөллийг багтаасан шүүгчдийн бүрэлдэхүүн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны дотор эцсийн шалгаруулалтыг хийнэ.

- Шүүгчид ирүүлсэн бүтээлийн утга санаа, уран сэтгэмж, өгүүлэмж, тайлбар, чанар, бүтээлийн агуулга ба нэр, тэдгээрийн шүтэлцээ зэргийг үндэслэн доорх байдлаар 0-5 оноогоор дүгнэнэ. Үүнд:

- 5 оноо = Онц сайн
- 4 оноо = Маш сайн
- 3 оноо = Сайн
- 2 оноо = Дунд зэрэг
- 1 оноо = Шаардлага хангасан
- 0 оноо = Шаардлага хангаагүй

Уралдаанд бүтээлээ ирүүлсэн оролцогчид шүүгч тус бүрээс ямар ч үнэлгээ авах магадлалтай бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг хангасан оролцогч байр эзэлнэ.

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Шалгаруулалтад Баримтат болон зохиомжит гэрэл зургийн төрөл бүрт 1-р байр 1, 2-р байр 2, 3-р байр 3, тусгай байр 4, нийт шилдэг 20 гэрэл зургийг шалгаруулна. Төрөл бүрээс тэргүүн байранд шалгарсан нэг, нэг гэрэл зургийг Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE)-ийн “Байгаль орчны залуу сурвалжлагч” олон улсын уралдаанд оролцуулна.

1-р Байр - 2 (300,000) гурван зуун мянган төгрөг, өргөмжлөл
2-р байр - 4 (250,000) хоёр зуун тавин мянган төгрөг, өргөмжлөл
3-р байр – 6 (200,000) хоёр зуун мянган төгрөг, өргөмжлөл
Тусгай байр – 8 (100,000) зуун мянган төгрөг, өргөмжлөл

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

- Хүүхдүүд хүрээлэн буй орчин, байгаль эх дэлхийгээ танин мэдэж, эргэн тойрныг шинжлэх, судлах хүсэл тэмүүлэлтэй болох;
- Хүрээлэн буй амьд ертөнцийг хайрлан хамгаалах ухамсрыг гэрэл зургаар дамжуулан бий болгох, олон нийтэд өөрийн үзэл санаагаар сурталчлан, таниулах,
- Хүүхэд, залуусын авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх,

НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ
- “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв” ТББ

ЕС. ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан 9, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв. Утас: 99153165, 99085775, 92050506